

ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХУВЬЦААТ КОМПАНИ

**2025 оны 12 дугаар сарын 31-ний
өдрөөр дуусгавар болсон жилийн**

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

(Хараат бус аудиторын дүгнэлтийн хамт)

**УЛААНБААТАР ХОТ
2026 он**

Агуулга

Хуудас

Компанийн мэдээлэл	1
Санхүүгийн тайлангийн талаарх удирдлагын хариуцлагын мэдэгдэл	2
Хараат бус аудиторын дүгнэлт	3-7
Санхүүгийн байдлын тайлан	8
Ашиг, алдагдал ба усад дэлгэрэнгүй орлогын тайлан	9
Өмчийн өөрчлөлтийн тайлан	10
Мөнгөн гүйлгээний тайлан	11
Санхүүгийн тайлангийн тодруулгууд	12-54

ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК
Компанийн мэдээлэл

Компани үүсгэн
байгуулагдсан
тухай:

Газар Шим Үйлдвэр ХК нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн
албанд 2007 оны 7-р сарын 20-ны өдөр бүртгүүлж, 2577127 тоот
регистрийн дугаартай гэрчилгээ авсан.

Төлөөлөн Удирдах Зөвлөл:

Ш.Алтанбагана

ТУЗ-ийн дарга

Д.Сэргэлэн

ТУЗ-ийн гишүүн

Ц.Төгсөө

ТУЗ-ийн гишүүн

З.Байгальмаа

ТУЗ-ийн гишүүн

Ц.Ганбат

ТУЗ-ийн гишүүн

Д.Гансүх

ТУЗ-ийн гишүүн

В.Ганзориг

Хараат бус ТУЗ-ийн гишүүн

Ч.Баяртуул

Хараат бус ТУЗ-ийн гишүүн

Д.Энх-Отгон

Хараат бус ТУЗ-ийн гишүүн

З.Байгальмаа

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гүйцэтгэх захирал

Ц.Ганбат

Албан ёсны хаяг

Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
20-р хороо, үйлдвэрийн бүс, 66/2

Хараат бус аудитор

Солид Юнити Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Бээжингийн гудамж,
Жи Би Плаза, 9-р давхар 904 тоот

Санхүүгийн Тайлангийн Талаарх Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл

Компанийн удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэх, тайлагнах үүрэгтэй.

Газар Шим Үйлдвэр ХК (цаашид “Компани” гэх)-ийн санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэгдсэн. Удирдлага нь энэхүү 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жилийн эцсийн санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлсэн болохыг баталгаажуулах үүрэгтэй.

Удирдлага нь компанийн санхүүгийн тайланг тодруулга 2 ба 3-т дурдсан шаардлагуудад нийцсэн гэдгийг баталгаажуулах боломжийг хангах, санхүүгийн байдлыг үндэслэлтэй, үнэн зөвөөр илэрхийлж чадах зөв зохистой нягтлан бодох бүртгэлийг хөтөлж бэлтгэсэн гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мөн удирдлага нь компанийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа залилан ашиглан, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх ерөнхий үүрэгтэй.

Удирдлага нь 6-аас 54 дугаар хуудсанд илэрхийлсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгон, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийн, холбогдох бүх нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн гэж үзэж байна.


Ц.Ганбат
Гүйцэтгэх захирал


М.Хурцбилэг
Санхүү, төлөвлөлт бүртгэлийн
албаны дарга

Монгол Улс,
Улаанбаатар хот
2026 оны 3 дугаар сарын 16-ны өдөр

**СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК**

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бээжингийн гудамж, Жи Би Плаза, 9-р давхар 904 тоот

Утас: 976+99063227,

976+9909 1993

и-мэйл: info@solidunity.mn

вэб: solidunity.mn

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Газар Шим Үйлдвэр ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

Бид Газар Шим Үйлдвэр ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, энэхүү санхүүгийн тайлангууд нь Газар Шим Үйлдвэр ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн баталсан Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрэм (Хараат Бус Байдлын Олон Улсын Стандарт үүнд хамаарна) (цаашид “НБЁЗОУСЗ-ийн Ёс зүйн Дүрэм” гэх) болон санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Монгол Улс дахь ёс зүйн зохих шаардлагуудын дагуу Компаниас хараат бус байж, НБЁЗОУСЗ-ийн Ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна

Аудитын гол асуудлууд

Тайлант жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитад хамгийн их ач холбогдолтой асуудлуудыг бид өөрсдийн мэргэжлийн үнэлэмжийг ашиглан аудитын гол асуудалд оруулсан. Бид санхүүгийн тайлангийн дүгнэлтийн хэлбэрийг сонгохдоо эдгээр асуудалд анхаарсан ба эдгээр асуудлын талаар тусад нь дүгнэлт гаргаагүй. Бид дараах асуудлуудыг Аудитын гол асуудал гэж тодорхойлсон болно.

Хараат бус аудиторын тайлан (үргэлжлэл)

Аудитын гол асуудлууд (үргэлжлэл)

Аудитын гол асуудлууд	Тэдгээрийг шийдвэрлэсэн аудитын арга хэмжээ
Орлого хүлээн зөвшөөрөлт	
Аудитын Олон Улсын Стандартын дагуу орлого хүлээн зөвшөөрөлттэй холбоотой урьдчилан таамагласан залилангийн эрсдэл байдаг гэж үздэг. Удирдлага төлөвлөсөн үр дүндээ хүрэх зорилт, шахалт байх тул бид энэхүү эрсдэлийг орлого бий болох үед үүсэх боломжтой эрсдэл гэж тодорхойлсон. Дээрх хүчин зүйлстэй холбоотойгоор бид борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлтийг санхүүгийн тайлангийн гол онцлох зүйл гэж авч үзсэн.	Борлуулалтын орлогын хувьд гүйцэтгэсэн аудитын горимууд: - Бид батлагдсан үнийн дагуу харилцагчдад бэлэн бүтээгдэхүүнийг нийлүүлж буй болон бараа материалын борлуулалтын тоо хэмжээ, орлогын дүн, тоо хэмжээ, орлогын хүлээн зөвшөөрөлтийг анхаарч үзсэн. - Бид борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлтийн цаг хугацаа, бодитоор оршин байгаа эсэх, үнэн зөв эсэхийг хянаж буй хяналтуудад илүү анхаарлаа хандуулсан ба удирдлагын борлуулалт, борлуулалтын орлогын хүлээн зөвшөөрөлттэй холбоотой хэрэгжүүлж буй хяналтуудаас сонгон авч, эдгээр хяналтуудыг тестлэн шалгасан. - Бид борлуулалтын орлогыг зохих тайлант хугацаанд нь борлуулалтын гэрээнд тусгасан нөхцөлийн дагуу бүртгэсэн эсэхийг жилийн эцэстэй ойр бүртгэсэн борлуулалтын ажил гүйлгээг түүвэрлэн сонгож, барааны зарлагын баримт эсвэл борлуулсан барааг хүргэж өгсөн үед харилцагч хүлээн авсныг баталгаажуулсан баримттай харьцуулж үнэлсэн. - Бид орлого хүлээн зөвшөөрөх ердийн үйл явцаас гадуур борлуулалтын орлогын журналын бичилтүүд хийгдсэн эсэхийг шалгасан. - Бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгуудыг СТОУС 15-ын шаардлагын дагуу шинжилж үзсэн.
Хөнгөлөлттэй зээл	
Засгийн газраас Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэгчид, хоршоодын нэмүү өртгийн сүлжээний хөрөнгө оруулалтыг дэмжих үүднээс Компанид хүүгийн таатай нөхцөлөөр зээл олгосон. Зах зээлийн хүүгээс бага хүүтэй хөнгөлөлттэй зээлүүдийг СТОУС-9 дагуу бодит үнэ цэнээр бүртгэх шаардлагатай.	Бидний хэрэгжүүлсэн аудитын горим уулад: - Бид холбогдох зээлийн гэрээ, түүний нэмэлт өөрчлөлтийг хянаж, компанийн зүгээс дагаж мөрдсөн байдлыг үнэлсэн.

Компанийн хувьд тавигдах нөхцөлүүд нь зээлийн эргэн төлөлт болон үйлчилгээний шаардлагыг хангаж, үйл ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэхэд санхүүжилтийг ашиглах юм. Удирдлагын тооцоолсон хөнгөлөлттэй зээлийн тооцоолол нь ижил төстэй шинж чанар, нөхцөл бүхий зээлд тохирсон зах зээлийн хүүг үнэлсэн удирдлагын үнэлэмжийг ихээр оролцуулсан. 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар хөнгөлөлттэй зээлд хамаарах хойшлогдсон орлого 1,26,026,811.84 төгрөг байсан ба энэ нь Компанийн санхүүгийн тайлангийн хувьд материаллаг байсан. Компанийн санхүүгийн тайлангийн тодруулга 15-т тодруулсан болно.	- Бид шинээр эсвэл нэмэлт өөрчлөлтөөр олгогдсон хөнгөлөлттэй зээлүүд, зээлийн бодит үнэ цэний хөнгөлөлтийн буцаалт зэрэгтэй холбоотой дүнг дахин тооцоолсон. - Бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгуудын зохистой байдлыг мөн үнэлсэн болно.
<i>Бараа материалын хэрэгжилт</i>	
НББОУС 2 Бараа материалд Компанийн бараа материалыг өртөг болон цэвэр боломжит үнэ цэний аль багаар бүртгэхийг шаарддаг. Цэвэр боломжит үнэ цэний тооцоолол нь бараа материалыг бэлэн болгох нийт зардал болон борлуулалтын цэвэр үнийг харьцуулах замаар тодорхойлно. 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх бараа материалын дансны үнэ нь 14,933,492,520.91 төгрөг (2024 онд 12,427,270,303.41) байна. Санхүүгийн тайлангийн тодруулга 8-г харна уу.	Бидний хэрэгжүүлсэн аудитын горим уудад: - Үйлдвэрлэлийн өртгийн бодитой байдлыг үнэлсэн. - Борлуулалттай холбоотой зардлыг таамаглаж ТУЗ-ийн баталсан борлуулалтын үнээр дамжуулан цэвэр борлуулалтын үнийг таамагласан. - Санхүүгийн тайлан дахь холбогдох тодруулгын зохистой эсэхийг үнэлсэн.

Хараат бус аудиторын тайлан (үргэлжлэл)

Бусад Мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээх юм. Бусад мэдээлэл гэдэгт жилийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба санхүүгийн тайлан болон манай аудиторын тайлан үүнд хамаарахгүй болно.

Санхүүгийн тайлан дахь бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.

Бусад мэдээлэлтэй уншиж танилцан, уг мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад олж авсан бидний ойлголттой материаллаг хэмжээгээр нийцэхгүй эсвэл материаллагаар буруу илэрхийлэгдсэн зүйлс байгаа эсэхийг шалгах нь санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бидний хүлээх үүрэг, хариуцлага юм.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид СТОУС гэх)-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах үүрэг, хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг алдаанаас ангид санхүүгийн тайланг бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай дотоод хяналтыг тодорхойлох үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх компанийн чадамжийг үнэлж, тодруулах, шаардлагатай бол компанийг татан буулгахаар, эсвэл үйл ажиллагааг нь зогсоохоор, эсвэл ингэхээс өөр бодит хувилбар байхгүйгээр төлөвлөснөөс бусад тохиолдолд тасралтгүй ажиллагаатай холбоотой асуудал болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй ажиллагааны зарчмыг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ. Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Бидний зорилго нь санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг багтаасан тайлан гаргах юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-н дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлж байна гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Бид АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар мэргэжлийн шүүмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг ба бид,

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, уг эрсдэлийг үнэлэн, эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.

Хараат бус аудиторын тайлан (үргэлжлэл)

- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүйд хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн ерөнхий тодруулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бусад

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг. Мөн бид засаглах эрх бүхий этгээдүүдэд хараат бус байдлын талаарх холбогдох ёс зүйн шаардлагыг биелүүлсэн талаарх мэдэгдлийг хийдэг бөгөөд шаардлагатай үед бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц бүхий л харилцаа болон бусад асуудлууд, хараат бус байдлын эрсдэлийг бууруулсан эсвэл түүний эсрэг авсан хамгаалалтын хариу үйлдлүүдийн талаарх мэдэгдлийг хийдэг.

Засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас бид тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн өндөр ач холбогдолтой гэж үзсэн зүйлсийг аудитын гол онцлох зүйлс хэмээн тодотгосон болно. Бид аудитын гол онцлох зүйлсийг хууль тогтоомжоор нийтэд ил болгохыг хориглоогүй үед эсвэл маш ховор тохиолдолд тайланд тодруулахгүй байх нь тодруулснаас илүүтэйгээр олон нийтийн эрх ашигт нийцнэ гэж үзсэнээс уг онцлох зүйлсийг тайланд оруулахгүй хэмээн шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд эдгээр зүйлсийг тайландаа оруулдаг.

6471535 СБА9939
СОЛИД ЮНИТИ
АУДИТ ХХК
Солид Юнити Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Бээжингийн гудамж, Жи Би Плаза,
9-р давхар, 904 тоот
2026 оны 3 дугаар сарын 16-ны өдөр

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2026 оны 3 дугаар сарын 16-ны өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүйг анхаарна уу.

ГАЗАР ШИМТ ҮЙЛДВЭР ХК
Санхүүгийн Байдлын Тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

(Төгрөгөөр)	Тодруулга	2025.12.31	2024.12.31
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	6,28,29	4,023,403,741.09	5,883,196,555.14
Дансны авлага	7,27,29	7,158,658,685.17	5,717,493,017.47
Бараа материал	8	14,933,492,520.51	12,427,270,303.41
Урьдчилж төлсөн зардал ба бусад авлага	9	5,138,607,840.56	6,845,660,234.83
Эргэлтийн хөрөнгийн дүн		31,254,162,787.33	30,873,620,110.85
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	10	23,676,541,663.76	22,542,740,979.47
Биет бус хөрөнгө	11	3,316,695,634.08	3,319,751,990.26
Дуусаагүй барилга	12	7,584,961,035.80	4,725,484,084.21
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		34,578,198,333.64	30,587,977,053.94
ХӨРӨНГИЙН ДҮН		65,832,361,120.97	61,461,597,164.79
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
Өр төлбөр			
Дансны ба бусад өр төлбөр	13,27,28,29	2,392,841,613.11	1,465,533,168.57
Орлогын албан татварын өглөг	25,26	499,366,663.23	421,365,864.94
Богино хугацаат зээл	14,28,29	1,416,491.50	2,046,472,246.21
Гэрээний өр төлбөр		1,553,700,489.15	-
Богино хугацаат хойшлуулсан орлого	15	529,642,844.16	514,083,918.53
Богино хугацаат өр төлбөрийн дүн		4,976,968,101.15	4,447,455,198.25
Урт хугацаат зээл	14,28,29	4,128,616,033.12	3,584,706,096.91
Урт хугацаат хойшлуулсан орлого	15	496,383,967.68	665,293,903.37
Хойшлогдсон татварын өр	25	96,289,888.40	48,220,314.57
Урт хугацаат өр төлбөрийн дүн		4,721,289,889.20	4,298,220,314.85
Нийт өр төлбөрийн дүн		9,686,240,596.90	8,745,675,513.10
Эздийн өмч			
Хувьцаат капитал	16	131,792,452.77	131,792,452.77
Нэмж төлөгдсөн капитал	17	9,848,102,471.07	9,848,102,471.07
Дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц	10	12,189,209,330.84	12,308,611,905.44
Хуримтлагдсан ашиг		33,964,998,875.94	30,427,414,822.41
Эздийн өмчийн дүн		56,134,103,130.62	52,715,921,651.69
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ ДҮН		65,832,361,120.97	61,461,597,164.79

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн саллигүй хэсэг болно.

ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК

Ашиг Алдагдал ба Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

(Төгрөгөөр)	Тодруулга	2025.12.31	2024.12.31
Борлуулалтын орлого	18,26	47,197,953,534.37	41,071,890,186.85
Борлуулалтын өртөг	19,26	(28,252,420,676.42)	(23,609,900,126.52)
Нийт ашиг		18,945,532,857.95	17,461,990,060.33
Ерөнхий удирдлагын зардал	20,26	(3,596,584,592.29)	(2,928,770,401.26)
Борлуулалт, маркетингийн зардал	21,26	(7,448,269,378.37)	(5,177,813,153.10)
Үйл ажиллагааны ашиг		7,900,678,887.29	9,355,406,505.97
Санхүүгийн ашиг, алдагдал	24,26	(337,593,932.53)	7,377,210.04
Бусад орлого	22,26	664,651,708.75	805,840,911.26
Бусад зардал	23,26	(574,991,161.14)	(1,177,390,821.07)
Татварын өмнөх ашиг		7,652,745,502.37	8,991,233,806.20
Орлогын албан татварын зардал	25	(1,119,515,204.93)	(1,432,271,478.37)
Тайлант жилийн цэвэр ашиг		6,533,230,297.44	7,558,962,327.83
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	10	-	12,308,611,905.44
Тайлант үеийн нийт дэлгэрэнгүй орлого		6,533,230,297.44	19,867,574,233.27
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг		5.46	16.60

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салиггүй хэсэг болно.

ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК
Өмчийн Өөрчлөлтийн Тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

(Төгрөгөөр)	Хувьцаат капитал (Тод 16)	Нэмэгдэж төлөгдсөн капитал (Тод 17)	Дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц (Тод 10)	Хуримтлагдсан ашиг	Нийт эздийн өмчийн дүн
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	131,792,452.77	9,848,102,471.07	-	28,475,622,303.34	38,455,517,227.18
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
2024 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	131,792,452.77	9,848,102,471.07	-	28,475,622,303.34	38,455,517,227.18
Зарласан ногдол ашиг	-	-	-	(5,607,169,808.76)	(5,607,169,808.76)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	12,308,611,905.44	-	12,308,611,905.44
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-		7,558,962,327.83	7,558,962,327.83
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	131,792,452.77	9,848,102,471.07	12,308,611,905.44	30,427,414,822.41	52,715,921,651.69
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	45,519.49	45,519.49
2025 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	131,792,452.77	9,848,102,471.07	12,308,611,905.44	30,427,460,341.90	52,715,967,171.18
Зарласан ногдол ашиг	-	-	-	(3,115,094,338.00)	(3,115,094,338.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжилт	-	-	(119,402,574.60)	119,402,574.60	-
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	-	6,533,230,297.44	6,533,230,297.44
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	131,792,452.77	9,848,102,471.07	12,189,209,330.84	33,964,998,875.94	56,134,103,130.62

ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК
Мөнгөн Гүйлгээний Тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

(Төгрөгөөр)	2025.12.31	2024.12.31
Үндсэн үйл ажиллагаа		
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого:	51,967,929,512.42	44,282,941,964.95
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	48,363,800,491.23	41,330,110,261.62
Даатгалын байгууллагаас хүлээн авсан		-
Бусад мөнгөн орлого	3,604,129,021.19	2,952,831,703.33
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага:	45,255,024,773.56	42,987,663,584.80
Ажиллагчдад төлсөн мөнгө	7,215,002,499.92	5,017,253,596.78
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,831,317,011.64	1,087,802,935.02
Бараа материал худалдан авахад төлсөн	20,529,794,232.66	18,122,500,463.66
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	1,027,852,882.63	841,321,685.79
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	3,583,545,511.93	3,414,958,581.72
Төлсөн хүү	588,646,671.90	540,740,753.33
Төлсөн татвар	6,922,027,391.50	7,216,020,514.57
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	17,188,387.69	15,899,028.00
Бусад зардалд төлсөн мөнгө	3,539,650,183.69	6,731,166,025.93
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	6,712,904,738.86	1,295,278,380.15
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа		
Худалдсан үндсэн хөрөнгийн орлого		5,000,000.00
Худалдсан урт хугацаат хөрөнгийн орлого		
Хүлээн авсан хүүгийн орлого	643,563,320.45	401,278,371.38
Бусдад олгосон зээл болон урьдчилгааны буцаан төлөлт	44,481,898.00	1,979,415,862.48
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(5,901,366,306.12)	(8,833,489,381.23)
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(18,602,048.13)	(48,643,590.00)
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	(42,179.50)	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	(1,285,525,346.00)	(779,952,510.90)
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	(6,517,490,661.30)	(7,276,391,248.27)
Санхүүгийн үйл ажиллагаа		
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	9,420,000,000.00	-
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	(9,473,751,942.04)	(2,458,950,590.46)
Төлсөн ногдол ашиг	(1,947,465,595.54)	(5,711,795,936.52)
Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ	(2,001,217,537.58)	(8,170,746,526.98)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,805,803,460.02)	(14,151,859,395.10)
Гадаад валютын ханшийн зөрүүгийн ашиг (алдагдал)	(53,989,354.03)	(27,887,734.90)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,883,196,555.14	20,062,943,685.14
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,023,403,741.09	5,883,196,555.14